

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Ц.НЯМДОРЖ

**МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ
ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараахь хууль зүйн болон практик шаардлага байна. Үүнд:

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Мөнгө угаах болон терроризмын санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас анх 2006 оны 07 дугаар сарын 8-ний өдөр баталсан бөгөөд Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллага (цаашид “ФАТФ” гэх)-ын Ази номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг өөрийн гишүүн орны мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тогтолцоог тодорхой давтамжтай үнэлж, дүгнэдэг ба тус бүлгээс 2006 онд анх удаа Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд үнэлгээ хийсэн байна.

ФАТФ-ын тухайн үеийн зөвлөмжид нийцүүлэн боловсруулсан Мөнгө угаах болон терроризмын санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Их Хурлаас 2013 оны 05 дугаар сарын 31-ний өдөр баталсан боловч ФАТФ-ын зөвлөмжид зарим хуулийн зохицуулалтыг нийцүүлээгүй гэх үндэслэлээр “өндөр эрсдэлтэй болон хамтран ажилладаггүй улс” гэсэн ангилал буюу “хар саарал жагсаалтад” оруулж байсан бөгөөд 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох зохицуулалтыг ФАТФ-ын зөвлөмжид нийцүүлснээр манай улсыг дээрх дутагдлаа залруулсан гэж үнэлэн 2014 оны 6 дугаар сард “хар саарал жагсаалт”-аас гаргаж байжээ.

Ази номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс 2016 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаарх Монгол Улсын мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тогтолцоонд Харилцан үнэлгээг дахин хийж, үнэлгээний тайланг 2017 оны 07 дугаар сард Шри-Ланка Улсын Коломбо хотод зохион байгуулагдсан Ази номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 20 дахь удаагийн жилийн ээлжит хурлаар баталжээ.

Дээрх хурлаар Монгол Улсад 2018 оны 10 дугаар сар хүртэлх 15 сарын хугацаанд нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмж өгч тухай бүрт тайлагнахыг үүрэг болгосноос гадна Монгол Улсын Их Хурлын 2016

оны 68 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл”-д Мөнгө угаах болон терроризмын санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр тусгажээ.

Түүнчлэн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 19/15 тоот Мөнгө угаахтай тэмцэх зарим арга хэмжээний тухай зөвлөмжид ФАТФ-ын зөвлөмжийг төрийн бүх шатны байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах гэж тусгажээ.

1.2. Практик үндэслэл, шаардлага

Манай улсад 2018 оны 10 дугаар сар хүртэлх 15 сарын хугацаанд нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж өгч тухай бүрт тайлагнахыг үүрэг болгосонтой холбогдуулан зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ аваагүй, эсхүл хэрэгжүүлээгүй тохиолдолд ФАТФ-ын “зөвлөмжийг хэрэгжүүлдэггүй улс буюу хар жагсаалт”, эсхүл “зөвлөмжийг хангалтгүй хэрэгжүүлдэг буюу саарал жагсаалт”- д орох эрсдэлтэй төдийгүй үүнээс улбаалан манай улсын эдийн засгийн аюулгүй байдал, санхүүгийн салбарт сөрөг нөлөө үзүүлэх хориг арга хэмжээг олон улсаас авч хэрэгжүүлэх эрсдэл үүсэх болно.

Түүнчлэн Мөнгө угаах болон терроризмын санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсанаас хойш олон улсын мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тогтолцоонд гарсан өөрчлөлт, өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагаас манай улсад үзүүлсэн техник туслалцааны хүрээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, эрх зүйн орчинг ФАТФ-ын 40 зөвлөмжинд нийцүүлэх талаар зөвлөсөөр байна.

Энэхүү ФАТФ-ын 40 зөвлөмж нь аливаа улс орны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичгийн суурь болж буй олон улсын стандарт төдийгүй уг стандарт зөвлөмжийг хэрэгжүүлдэг улс орны хувьд санхүүгийн салбарт бусад улс оронтой хамтран таатай орчин бүрдэх үндэс болдог.

Иймд хууль өөрөө цаг үе, нийгмийн хэрэгцээ, шаардлагад бүрэн нийцсэн, аливаа зөрчил, хийдэлгүй байх нийтлэг зарчимд тулгуурлан ФАТФ-ын 40 зөвлөмжид нийцүүлэн Мөнгө угаах болон терроризмын санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах дараахь зайлшгүй практик шаардлагууд үүсч байна. Үүнд:

-Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны эрх зүйн байдал, үйл ажиллагааны чадамжийг бэхжүүлэх;

-Санхүүгийн үйлчилгээний хөгжил, техник технологийн өөрчлөлтөд нийцүүлэн “мэдээлэх үүрэгтэй этгээд”-ийн хүрээг өргөжүүлэх, тэдгээртэй холбоотой зохицуулалтыг нийцүүлэх;

-Мэдээлэх үүрэгтэй этгээдэд тавих хяналт шалгалтын тогтолцоог эрсдэлд суурилсан хэлбэрт оруулах нөхцөлийг бүрдүүлэх;

-Эдийн засгийн харилцаанд орж байгаа аливаа хөрөнгийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг үнэн зөв, бодитоор бүртгэх тогтолцоог бүртгэлийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх;

-Хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог сайжруулах;

-Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

-Терроризмыг санхүүжүүлэхээс гадна үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх зохицуулалтыг тусгах;

-Хамтын ажиллагааны зөвлөлөөс гадна Засгийн газрын түвшний Үндэсний зөвлөлийн талаарх зохицуулалтыг хуульд тусгах.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасныг үндэслэн хуульд шинээр зүйл, хэсэг, заалт оруулах, өөрчлөх, хүчингүй болсонд тооцох зэргээр нэмэлт, өөрчлөлт орж байгаа тул хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд дээр дурдсан практик хэрэгцээ шаардлагад үндэслэн зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараахь байдлаар тусгана. Үүнд:

-Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны эрх зүйн байдал, үйл ажиллагааны чадамжийг бэхжүүлэх зорилгоор хуульд тус албаны чиг үүрэг, эрх хэмжээний талаарх зохицуулалтыг нэмж тусгана;

-Хуулийн нэр томъёоны зарим тодорхойлолтыг ФАТФ-ын 40 зөвлөмжид заасан стандартад нийцүүлнэ;

-“Мэдээлэх үүрэгтэй этгээд”-ийн хүрээг ФАТФ-ын 40 зөвлөмжид нийцүүлэн өргөжүүлж, тэдгээртэй холбогдох зохицуулалтыг нийцүүлэн өөрчлөн найруулна;

-Мэдээлэх үүрэгтэй этгээдэд тавих хяналт шалгалтын тогтолцоог эрсдэлд суурилсан хэлбэрт оруулах нөхцөлийг бүрдүүлэхээс гадна мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналтын хөтөлбөр болон харилцагчийг таньж мэдэх талаарх зохицуулалтыг ФАТФ-ын 40 зөвлөмжид нийцүүлэн боловсронгуй болгоно;

-Эцсийн өмчлөгчийг тогтоох, харилцагчийг таньж мэдэх ажиллагаа, уг ажиллагааг гуравдагч этгээдээр хийлгэхэд тавигдах шаардлага, эрсдэлийн үнэлгээ, дотоод хяналтын хөтөлбөр, хориг арга хэмжээний жагсаалт гэх зэрэг зохицуулалтыг хуульд тусгаж, үүнтэй холбоотой нарийвчилсан ажиллагааг “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-аар зохицуулах асуудлыг тусгахдаа төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны даргын саналыг үндэслэн журмыг баталдаг байхаар өөрчилнэ;

-Эдийн засгийн харилцаанд орж байгаа аливаа хөрөнгийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг үнэн зөв, бодитоор бүртгэх тогтолцоог бүртгэлийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлнэ;

-Мэдээллийн нууцлалыг хадгалах зохицуулалтыг Харилцан үнэлгээний тайлангийн зөвлөмжид нийцүүлэхээс гадна хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгон Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуультай уялдуулна;

-Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно;

-Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх аливаа хуулийн зохицуулалт нь “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх”-д нэг адил үйлчлэх талаар хуульд тусгана. Ингэхдээ терроризм, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх асуудал тагнуулын байгууллагад, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал Санхүүгийн мэдээллийн албанд хамаарахаар тусгана;

-Хамтын ажиллагааны зөвлөлөөс гадна Засгийн газрын түвшинд Үндэсний зөвлөл ажиллах талаар хуульд тусгана;

-Дээр дурдсан асуудалтай холбогдуулан хуулийн бусад шаардлагатай зохицуулалтыг ФАТФ-ын 40 зөвлөмжид нийцүүлнэ.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар дараахь эерэг үр дүн гарна:

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, эрх зүйн орчин боловсронгуй болно;

- Монгол Улс олон улсад хүлээсэн үүргээ биелүүлж, дотоодын хууль тогтоомжийг Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага (ФАТФ)-ын 40 зөвлөмжид нийцүүлэх алхамд ахиц гарна;
- Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, санхүүгийн салбарт сөрөг нөлөө үзүүлэх хориг арга хэмжээг олон улсаас авч хэрэгжүүлэх эрсдлээс урьдчилан сэргийлнэ;
- Санхүүгийн мэдээллийн албаны чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл бололцоо сайжирна;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх хариуцлагын тогтолцоо сайжирна;
- Хуулийн хэрэгжилт сайжирч, холбогдох байгууллагын хамтын ажиллагаа бэхжин үйл ажиллагааны чадавх дээшилнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой улсын төсөвт ачаалал үүсэхгүй.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн тухай

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцсэн байна.

Уг хуулийн төсөлтэй уялдуулан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Терроризмтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, “Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолийн төслийг тус тус боловсруулна.

---000---